

Хүүхэд хамгааллын бодлого

ШУТИС-ийн БУХС Нийгмийн Ухааны салбарын
профессор, доктор Ph.D Т. Амаржаргал



Агуулга

- Хүүхэд хамгааллын тухай товч өгүүлэх нь
- Хүүхэдтэй зүй бусаар харьцах явдлын үр дагавар
- Хүүхэд хамгааллын бодлого



Хүүхэд хамгааллын тухай ӨГҮҮЛЭХ НЬ

- **Хүүхэд хамгаалал:** Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг гарахаас урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэхэд чиглэсэн санаачилга, үйл ажиллагаа



Хүүхдийн эсрэг хүчирхийлэл:

- бие мах бодын хүчирхийлэл
- бэлгийн хүчирхийлэл
- сэтгэл санааны хүчирхийлэл
- үл хайхрах
- бүх хэлбэрийн мөлжлөг



Бие махбодийн хүчирхийлэл:

- зодох, цохих, өшиглөх, хазах, түлэх, сэгсрэх чимхэх, гэх мэт ямар нэгэн байдлаар хүүхдийн бие махбодод байнга халдах, бие мах бодын гэмтэл учруулах үйлдэл



Бэлгийн хүчирхийлэл:

- Хүүхдийг бэлгийн таашаал авахдаа ашиглах, эдийн засгийн ашиг олохоор биеийг нь үнэлүүлэх үйлдэл



Сэтгэл санааны хүчирхийлэл:

- Байнга голох, доромжлох, нэр төрийг нь гутаах, хүний эрхийг нь үгүйсгэх гэх мэтээр өөртөө итгэх итгэл, нийгмийн чадамжаа хүүхэд аажмаар гээхэд хүргэж байгаа бусдын сөрөг зан үйл





Үл хайхрах:

- Хүүхдэд анхаарал тавихыг шууд, санаатайгаар орхигдуулж, тэдний наад захын хэрэгцээг хангах явцдаа алдаа гаргах үйлдэл






Мөлжлөг:


- Хүүхдийн эмзэг байдлыг ашиглан тэднийг хүнд хөдөлмөр эрхлүүлэх, наймаалах, садар самуун болон бусад эрсдэлт үйл ажиллагаанд уруу татан ашиг хонжоо олох үйлдэл





Хүүхэдтэй зүй бусаар харьцах явдлын үр дагавар :


- Хүний тархины хөгжлийн хамгийн идэвхтэй, хурдацтай үе бол 6 хүртэлх нас юм.
- Хүүхэд эхээс мэндлэхэд 100 сая орчим тархины эс бүрэлдсэн байдаг бөгөөд түүний 90% нь хүүхдийн амьдралын эхний 5 жилд бүрэлдэн хөгждөг байна. НҮБ ын Хүүхдийн сангийн шинэ баримт нотолгоо

- 
- Хүүхдийн амьдралын эхний 3 жилийн идэвхтэй халуун дулаан харилцаа, туршлага хүний тархины насан туршийн хөгжлийн үндэс, тулгуур болно.
 - Хүүхдийн амьдралын эхний жилүүдэд тархины хөгжлийн хурдац насанд хүрэгчдээс 2 дахин илүү байдаг.


- 
- Үе дамжсан ядуурлаас ангижрах нэг арга зам бол бага насны хүүхдийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх явдал юм гэж дүгнэж байна.


- 
- Нотолгоо нь Бага насны хөгжлийн хөтөлбөр (СӨБ)-т хамрагдсан болон хамрагдаагүй 2 бүлэг хүүхдүүдийг 40 жилийн турш судалсан судлаачдын дүгнэлтээс үзвэл:


- 
- Илүү олон хүн ерөнхий боловсролын сургуулиа амжилттай дүүргэж, чанартай амьдрах чадавхтай болно (65% ба 45%)

- 
- Илүү олон хүн ажил эрхэлж, чанартай амьдарна (76% ба 62%)



- 
- Хадгаламжийн данс эзэмших магадал илүү (76% ба 50%)

- 
- Гэр бүл сарних/салах магадлал багасна (28% ба 52%)

- 
- Гэмт хэрэг багасч, шоронгийн зардал буурч, ял шийтгэл багасна (28% ба 52%) .

Хүүхдийн Хөгжил :



3 weeks



4 weeks



5 weeks



7 weeks



11 weeks



4 months




6 months



8 months



Newborn




At Birth

6 Years Old


14 Years Old

Synaptic Density in the Human Brain




Стресс нь уураг тархины бүтцэд гэмтэл учруулдаг


- Хэт их болон
байнгын стресс нь
эсийн өсөлтийг
гэмтээж улмаар
уураг тархины эрүүл
мэдрэлийн эсүүдийн
холбоос уудад саад
учруулдаг бодисыг
ялгаруулдаг.

- 
- Хортой стресс нь уураг тархинаас стрессд хариу үйлдэл үзүүлдэг системийг гэмтээдэг ба түүнчлэн бие махбодийг наснаасаа эрт хөгшрөхөд нөлөөлдөг.

Стресс нь уураг тархины бүтцэд гэмтэл учруулдаг





Эрүүл уураг тархи



Хүчирхийлэлд өртсөн уураг тархи


Хүүхдийг үл хайхрах нь уураг тархины хөгжилд хэрхэн нөлөөлдөг болох нь






Хүүхэдтэй зүй бусаар харьцах нь хүүхдийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг


- Ой санамж ба сургалтын амжилтанд сөргөөр нөлөөлнө:
 - Hippocampus төв нь ой тогтоолт ба сурах чадамжид гол үүрэг гүйцэтгэдэг ба стресийн гормон ба стресстэй холбоотой мэдрэлийн эсийн дамжуулагч системүүд нь Hippocampus төвд голлон нөлөөлдөг бөгөөд бүтэц хэмжээнд нь өөрчлөлтийг бий болгож мэдрэлийн эсийн хөгжилд саад учруулдаг. Эдгээр өөрчлөлтүүд нь ой тогтоолт ба сурах үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулдаг (Perry & Azad 1999)

- 
- АНУ-д хийгдсэн томоохон судалгаа нь зүй бусаар харьцах явдалд өртөж байсан хүүхэд, өртөж байгаагүй хүүхэд хоёрын сурлагын амжилт нь ихээхэн зөрүүтэй байгааг харуулсан (Eckensrode 1993)



■ Нийгмийн ба сэтгэлзүйн хөгжилд сөргөөр нөлөөлнө:

- Хэд хэдэн судалгаагаар бие махбодийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүд түрэмгий зан авиртай, үе тэнгийхэнтэйгээ харилцах харилцааны асуудалтай болох нь их байдаг бол харин үл хайхрах явдалд өртөж байсан хүүхдүүд оюуны болон бусад хөгжлийн хоцрогдолтой, ганцаардмал зожиг болох нь их байдагийг харуулсан байна. (Kent 1976, Prino & Peyrot 1994)



Эрдэмтэн Kent 1976 онд, эрдэмтэн Prino, Peyrot нар 1994, ЮНЕСКО –н судалгаа 2005 онд:

- Бие махбодийн шийтгэлд өртөж байсан хүүхдүүд бусадтай харьцуулахад ёс суртахууны төлөвшил доогуур буюу бусдыг өрөвдөх сэтгэлгүй улмаар янз бүрийн буруу зан үйлд татагдах нь их байдаг гэдгийг харуулсан.
- Үл хайхрах явдалд өртөж байсан хүүхэд оюуны болон бусад хөгжлийн хоцрогдолтой, ганцаардмал зожиг байдаг болохыг харуулсан



Эрдэмтэн Eckenrode

- АНУ-д хийсэн судалгаагаар зүй бус харьцах явдалд өртөж байсан хүүхэд, өртөж байгаагүй хоёр хүүхдийн сурлагын амжилт нь ихээхэн зөрүүтэйг 1993 онд нотолжээ.



Үр дагаврууд:


- Уураг тархины хөгжилд саад учруулдаг – чадамжийг бууруулдаг.
- Сурлагад муугаар нөлөөлнө /сургууль завсардах
- Хөдөлмөр эрхлэх чадвар доогуур / ур чадваргүй
- Эрсдэлтэй зан үйлд уруу татагдах, архи тамхи хэрэглэх

Үр дагаврууд:

- Эрт үеийн/өсвөр насны жирэмслэлт/эцэг эх байх чадвар сул
- Харилцааны чадваргүй болгоно
- Гэр бүл салалт /гэмт хэрэгт холбогдох
- Ядуурал болон хүчирхийлэл үе дамжих


Өвчин ба гэмтэлүүд

- 
- Зүрх судасны өвчнүүд
 - Чихэрийн шижэн
 - Даралт харвах
 - Хавдар
 - Амиа хорлох
 - Ясны хугарал
 - Архаг бронхит
 - Астма
 - БЗХӨ (ДОХ)
 - Гепатит



Хүүхэд насанд хүрэгчидтэй харьцуулбал 2-3 дахин илүү хохирол амсдаг

- эрүүл мэндээрээ хохирдог
- сурч боловсрох, хөгжих
- нийгмийн амьдралд оролцох
- бие хүний төлөвшил
- ирээдүйн амьдра

- 
- Хүүхдийн бие махбодь, эрүүл мэнд, сэтгэл санаа ба оюун ухаанд үзүүлэх дарамт, хүчирхийллийн үр нөлөөг судлаачид цаг хугацааны хувьд богино ба урт хугацааны үр дагавар гэж хувааж үздэг.



Богино хугацааны үр дагавар нь:

- Хүүхдийн оюун ухаан, танин мэдэхүйн чадвар буурах,
- Буадтай харилцах харилцаа сөрөг, догшин ширүүн болох
- Өөртөө итгэлтэй байдал нь буурах
- Хэл ярианы чадвар хязгаарлагдмал болох
- Аливаа зүйлд санаачилгатай хандах явдал буурах




Урт хугацааны үр дагавар нь

- Архи, тамхи бусад төрлийн мансуурах бодис хэрэглэх
- Биеэ үнэлэх
- Хүчирхийлэл дарамтын хохирогч болох, эсвэл өөрөө хүчирхийлэл үйлдэх
- Амиа хорлох



Хүүхдийн хамгаалуулах эрх


- НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенцид хүүхэд аливаа дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах явдлаас хамгаалуулах эрхтэй бөгөөд насанд хүртлээ эцэг эх, гэр бүл ба төрийн онцгой халамж, хамгаалалтанд байх шаардлагатай болохыг заажээ.


- 
- Хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдал зэрэг зүй бус бүх хандлага нь хүүхдийн жам ёсны эрх болох айдас хүйдсээс ангид, халдашгүй дархан байх эрхэмсэг чанарыг үгүйсгэсэн хүүхдийн эрхийн ноцтой зөрчил мөн бөгөөд хэзээ ч зөвтгөж болохгүй, харин урьдчилан сэргийлж болох, ёсзүй, хууль эрх зүйн хүрээнд **хүн бүрт** хамаатай асуудал юм.




Хүүхэд хамгааллын бодлого


- Энэ нь ажилтан, албан хаагчдад чиглэсэн үйлчилгээ эрхлэгчийн дотоод бодлого бөгөөд хүүхдэд учрах эрсдэл, хор нөлөөнөөс сэргийлж, хамгаалахын тулд иргэн бүр анхаарал тавьж байгааг нотолсон баримт бичиг.
- Хүүхэд хамгааллын бодлогод хүүхэд бүрт аюулгүй, эерэг орчин бүрдүүлэхийн тулд байгууллага, ажилтнууд, сайн дурын идэвхтнүүд болон бусад холбогдох хүмүүс юуг анхаарах ёстойг тусгадаг.

- 
- Хүүхэд бүх орчинд хүчирхийлэл дарамтанд өртөх эрсдэлтэй хүн амын бүлэг бөгөөд хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажилладаг байгууллага, салбарын үйлчилгээг авах явцад ч бас хүчирхийлэл, шийтгэлд өртөх явдал байдаг.
 - Иймд хүүхэд, гэр бүлтэй ажилладаг байгууллагуудад илүү өндөр шаардлага тавигддаг.
 - Эдгээр байгууллагууд нь хүүхэдтэй ажиллахдаа бүх хүүхдийг дээд зэргээр хамгаалах бүхий л арга хэмжээг авах ёстой.

- 
- Хүүхэд, гэр бүлтэй шууд ба шууд бусаар ажилладаг байгууллагууд тусгайлсан Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх нь олон улсын стандарт бөгөөд энэ нь аливаа эрсдэлээс хамгаалах сайн туршлага

ЮМ. Keeping Children Safe Coalition, (2011). Standards for Child Protection

- 
- Хүүхэд хамгааллын бодлого нь хүүхэд, гэр бүлийн төлөө болон хүүхэд гэр бүлтэй шууд тулж ажилладаг байгууллага, иргэнд зориулсан болно.
 - Энэ загвар нь__хүүхдэд зүй бус хандах бүх хэлбэрээс:
 1. Хэрхэн урьдчилан сэргийлэх,
 2. Эрсдэлийг хэрхэн бууруулах,
 3. Зөрчил гарсан тохиолдолд мэдээлдэг механизмыг бий болгох
 4. Хариу үйлчилгээг шуурхай үзүүлэх арга замыг тодруулахыг зорьсон болно.

- 
- НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенц, Монгол Улсын Хүүхдийн Эрхийг Хамгаалах тухай хуулийн дагуу хүүхэд бүр хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үйл хайхрах байдлаас хамгаалагдах эрхтэй.
 - Нас, сэтгэхүй, оюун ухаан, амьдралын онцлог байдлын улмаас хүүхэд бүр хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үйл хайхрах байдалд өртөх эрсдэлтэй байдаг. Хүүхдийг хамгаалах нь хүн бүрийн үүрэг.

ЗОРИЛГО

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг, үйл хайхрах байдал нь хүүхдийн эрхийн ноцтой зөрчил. Манай байгууллага, хамт олон Хүүхэд Хамгааллын Бодлогыг хэрэгжүүлэн хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйлсийг байгууллагын соёлд нэвтрүүлсэн хамт олон болж хүүхдийг хүндэтгэсэн нийгмийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулна.

ХАМРАХ ХҮРЭЭ

- Энэхүү бодлого нь байгууллагын үндсэн болон гэрээт бүх ажилтан, албан хаагчид, сайн дурын ажилтнуудад хамаарна. Мөн гадаадын ажиллагсдад энэ бодлого хамаарна.

Зохион байгуулалт

- Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах хүнийг томилно.
- Хүүхэд хамгааллын бодлогыг нийтэд харагдахуйц газар, байгууллага дээр болон цахим хуудсанд байрлуулна.



Хүүхэд хамгааллын талаар мэдээлэл түгээх, ажилтан, албан хаагчдыг эцэг эхийн үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- Ажилтан, албан хаагчдад хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, эерэг хүмүүжлийн арга болон холбогдох хууль эрхийн актуудын талаар мэдээлэл өгч, сургалт явуулж байна.
- Эцэг эх болон хүүхэд асран хамгаалагч ажилтнуудад эцэг эхийн үүргээ биелүүлэхийг дэмжиж, хүүхэдтэйгээ цаг өнгөрөөх, хүүхдэдээ халамж анхаарал тавих боломжийг олгохыг хичээн ажиллана.
- Хүүхэд үл хайхрагдах, эцэг эхийн халамж анхаарал алдагдах үндсэн шалтгаануудын нэг болох архины хамааралд ажилтан, албан хаагчдыг орохоос сэргийлэхийн тулд архинаас хамааралгүй, нийгмийн хариуцлагатай хамт олон болох хөдөлгөөн өрнүүлнэ.



Хүүхэд хамгааллын зөрчлийг мэдээлэх

- Хүүхдийн эсрэг бие мах бод, сэтгэл санааны болон бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, эдийн засгийн болон бэлгийн мөлжлөгт оруулсан, 18-аас доош насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон, хүүхдийг эсрэг бие махбод, сэтгэл санааны шийтгэл хэрэглэсэн, хүүхдийг дарамталсан, хүүхдээ үл хайхран эцэг эхийн үүргээ умартуулсан зэрэг **зөрчил илэрсэн тохиолдолд хүүхэд хамгааллын болон хууль цагдаагийн байгууллагад мэдээлдэг соёлыг ажилтнуудын дунд нэвтрүүлнэ.**




Эрсдэлийг бууруулах


- Байгууллагын үйл ажиллагаанд хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй аливаа эрсдэл байгаа эсэхийг судалж, эрсдэлийг бууруулах, хор нөлөөг нь багасгахад байнга анхаарч ажиллана.




ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Байгууллагын нийт ажилтны хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн гол зорилго нь хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад оршино.
- Гол зарчим нь байгууллагын ажилтны зүгээс хүүхэд хамгааллын эрсдэл, зохисгүй зан авир гаргахгүй байхад оршино.

- 
- 2-5 настай хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан харилцана;
 - Хүүхэд, том хүн хоёрын эрх мэдлийн зөрөөг ойлгож хүүхдэд дээрэнгүй хандахгүй байх;
 - Харилцааны зөв үлгэр дууриалал үзүүлэх;
 - Хүүхдийг хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэл хэрэглэхгүй байх, эерэг хүмүүжлийн аргыг ашиглах;

- 
- Хүүхдийн хувийн нууцлалд хүндэтгэлтэй хандах;
 - Хүүхдийг ашигласан садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг бусад зүйлсийг хэрэглэх нь хүүхдийг садар самуунд ашиглахыг дэмжиж байгаагийн илрэл болохыг ойлгож, ийм зүйлсээс татгалзах;
 - Хүүхдийн өөрөө хийж чадах зүйлийг өмнөөс нь хийхгүй байх;
 - Хүүхэд хамгааллын зөрчлийг тэвчихгүй байх, мэдээлэх, асуудлыг нуун дарагдуулдаггүй, нээлттэй ярилцдаг соёлыг түгээх;

- 
- Ажлаа төлөвлөх, гүйцэтгэхдээ хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол үзүүлж болзошгүй аливаа эрсдэлийг тооцож, сэргийлэх;
 - Хүүхдийн дунд гарч болзошгүй үе тэнгийнхний хүчирхийллийн талаар сонор сэрэмжтэй байх;
 - Хүүхэд хүн дамлан худалдах наймааны золиос болох зэрэг хүүхдэд хор учруулах үйл ажиллагаанаас сэргийлэх.

Хориглох

- Хүүхдийг цохих, зодох, тусгаарлан хорих зэргээр бие махбодын хүчирхийлэлд оруулах;
- Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, сэтгэл санааны дарамтанд оруулах, нэр хоч өгөх;
- Хүүхдийг бэлгийн харьцаа хандлагаар өдсөн тоглоом тоглох, шалиг үг яриа ярих зэргээр биеэ авч явах, бусдад тийм боломж олгох;

Хориглох

- Хууль бус эсвэл хүүхдэд аюултай үйлдэл гарсан тохиолдолд түүнийг тоохгүй орхих;
- Хүүхдийн дэргэд хараал, бүдүүлэг үг хэрэглэх;
- Хүүхдийг ямар нэг байдлаар нь ялгаварлан харьцах.



Хүүхдэд ээлтэй байгууллага:

- Бие махбод, бэлгийн, сэтгэл санааны, сэтгэл зүйн хохирол, үл хайхрах байдлаас хүүхдийг хамгаалах үйл ажиллагааг байгууллагын бүх түвшинд нэвтрүүлсэн дадал болгосон,
- дотоод журамдаа тусгасан,
- байгууллагын соёлд нэвт шингээсэн байгууллага